

4 ДҮГЭЭР АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ БЛЮПРИНТ

АНГИ, СУДЛАГДАХУУН		4 ДҮГЭЭР АНГИ, МОНГОЛ ХЭЛ								Нийт	Эзлэх хувь
ШАЛГАЛТ ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА		60 МИНУТ									
ДААЛГАВРЫН ХЭЛБЭР		СОНГОХ ДААЛГАВАР				ЗАДГАЙ ДААЛГАВАР					
АТБХ	Суралцахуйн зорилт	Мэдлэг ойлголт	Чадвар	Хэрэглээ	Бүгд	Мэдлэг ойлголт	Чадвар	Хэрэглээ	Бүгд		
	4.1.а. Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс олж агуулгыг тогтоох	1/1			1/1					1/1	4%
	4.1 б Уншсан эхийн болон үлгэр өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	1/1	1/1		2/2		1/2		1/2	3/4	17%
	4.2. в. ж, ч, ш-ийн дараа "и" бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих	1/1	1/1		2/2					2/2	8%
	4.2 б Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэх, зөв бичих						1/3		1/3	1/3	13%
	4.2 г Хатуу зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэж, зөв бичих	1/1	1/1		2/2					2/2	8%
	4.4 в Ойролцоо ба эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох	1/1	1/1		2/2					2/2	8%
	4.4 г Эх өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэх		1/1		1/1		1/2		1/2	2/3	13%
	4.4 а Харин ийм учраас, цаашилбал, үүнээс гална, яагаад гэвэл үүнээс болж, ба бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн эх зохиох						1/2		1/2	1/2	8%

4.2. к. Бүтцийн дагуу үлгэр зохиохдоо баатрын гадаад дүр байдлыг дүрслэн бичих							1/5	1/5	1/5	21%
НИЙТ ДААЛГАВРЫН ТОО, ОНОО	5/5	5/5		10/10		4/9	1/5	5/14	15/24	
ЭЗЛЭХ ХУВЬ	50%	50%		100%		64%	36%	100%		100%

ОНООНЫ ХЭВИЙН ТАРХАЛТ

Түвшин	Даалгаврын тоо	Онооны тоо	Даалгаврын эзлэх хувь	Онооны эзлэх хувь
Мэдлэг ойлголт	2	3	25%	23%
Чадвар	4	7	50%	54%
Хэрэглээ	2	3	25%	23%
Нийт	8	13	100%	100%

ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВРЫН ХАРИУ, ҮНЭЛЭХ СХЕМ

№	Суралцахуйн зорилт	Танин мэдэхүйн түвшин	Зөв хариулт А	Зөв хариулт Б	Оноо	Онооны тайлбар
НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР						
1	4.1 б Уншсан эхийн болон үлгэр өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	Ойлгох	А	А		Зөв хариултыг сонгосон бол 1 оноо
2	4.1.а. Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс олж агуулгыг тогтоох	Задлан шинжлэх	А	А		Зөв хариултыг сонгосон бол 1 оноо

3	4.2. в. ж, ч, ш-ийн дараа "и" бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих	Задлан шинжлэх	В	В		Зөв хариултыг сонгосон бол 1 оноо
4	4.1 б Уншсан эхийн болон үлгэр өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	Хэрэглэх	В	Г	2	Зөв хариултыг сонгосон бол 1 оноо
ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР						
5	4.1 б Уншсан эхийн болон үлгэр өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	Мэдлэг ойлголт	Би зуу гаруй авьяастай. Түүнээс гадна бас уут дүүрэн заль мэхтэй. үнэг сайрхав.	Би цорын ганц авьяастай.	2	Үнэг болон муурын сайрхсныг бүрэн хариулсан бол 2 оноо Дутуу оновчгүй бичсэн бол 1 оноо
6	4.2. в. ж, ч, ш-ийн дараа "и" бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих	Задлан шинжлэх	Тогоочийн шанага Зураачийн бийр Амралтын газар Газрын хөрс Багшийн ном Боломжийн асуулт	Сурагчийн ширээ Асуултын хариу Жолоочийн үнэмлэх Сувилагийн тариур Эмчийн чагнуур Шүүдрийн ус	3	Нөхцлөө зөв залгасан бол 0.5 оноо, холбоо үгээ үүсгэсэн бол 0.5 оноо
7	4.1 б Уншсан эхийн болон үлгэр өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	Задлан шинжлэх	Аливаа хүн онгирч сагсуурч болохгүйг сургамжилсан.гэх мэт		2	Үлгэрээс сургамж авснаа өөрийн үгээр тайлбарлан бичсэн бол 2 оноо Дутуу бичсэн бол 1 оноо
8	4.1 б Уншсан эхийн болон үлгэр өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	Хэрэглэх	1Б, 2В, 3Г,4А	1 Г,2В,3Б,4А	2	ААзын төрөл зүйлийг зөв харгалзуулан зурсан бол тус бүр 0.5 оноо
БИЧИХ ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ-8 ОНОО						
	4.1.и. Уншсан зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх 4.2.к. Бүтцийн дагуу үлгэр зохиохдоо баатрын гадаад дүр байдлыг дүрслэн бичих	Зохиосон үлгэрийн эхлэл, гол, төгсгөл хэсэг дэх цогцолборуудыг догол мөрөөр заагласан бол 3 оноо Цогцолборууд нь утгын уялдаа холбоотой байвал 3 оноо, (бүтцийн дагуу бичсэн бол) Зөв бичих дүрмийн алдаа гаргаагүй бол 2 оноо				

ЧУЛУУНХОРООТ СУМЫН СУРГУУЛИЙН IV АНГИЙН АНГИ ДЭВШИХ
ШАЛГАЛТЫН СЭДЭВ /МОНГОЛ ХЭЛ/

Суралцагчийн нэр

ХУГАЦАА – 60 МИН

“А” ВАРИАНТ

НИЙТ ОНОО –24

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй.

Үнэг ба муур

Нэгэн удаа муур үнэг авхайтай ойд учрах тохиолдол таарчээ. Үнэг тун ухаантай, юм үзэж нүд тайлсан, нэр нүүртэй гэдгийг мэдэх тул муур дээдийн дээдээр аашлан, түүнд хандаж,

- Амрыг эрье. Хонгорхон үнэг авхай, ойрд та амгалан сайн уу ? Энэ бэрх цагт хэр аж төрж сууна даа? хэмээв. Ихэрхүү зальт үнэг муурыг хөлөөс толгой хүртэл шинжин харж хариулъя уу, байя уу гэж баахан тээнэглэсэнээ:

- Оготно барьдаг өлбөгөр лүд. Алаг эрээн мангуу минь, чи яасан тэнэг юм ! Хэр аж төрж сууна уу ? гэж надаас яаж асууж зүрхэлнэ вэ ? Чи ер нь юу сурсан амьтан бэ? Ямар авьяастай вэ? гэж байцаажээ.

-Би цорын ганц авьяастай гэж муур даруухан хариулав.

-Тэр чинь ямар авьяастай вэ? гэж үнэг асуужээ.

-Хэрэв нохой хойноос минь хөөвөл модон дээр үсрэн гарч, амиа хамгаалж чадна.

Энүүхэн үү? гэсэнэ би зуу гаруй авьяастай. Түүнээс гадна бас уут дүүрэн заль мэхтэй.

Би чамайг хачин их өрөвдөж байна. Миний араас дагаад яв. Нохойноос хэрхэн нуугдах аргыг би чамд зааж өгье хэмээн үнэг сайрхав.

Яг энэ үед анчин дөрвөн нохой дагуулсаар гарч ирэхэд муур шалмаг гэгч нэгэн модон дээр үсрэн гарч, модны оройд мөчир навчинд халхлагдан суужээ.

-Уутаа онгойлгооч, үнэг авхай, уутаа онгойлго л доо! гэж муур үнэг уруу хашхирсан боловч ноход хэдийнээ түүнийг зуусан байв.

-Үнэг авхай минь. Хэрвээ та над шиг мод өөд авчирч чаддаг сан бол хар амиа бодож, өөрийнхөө амийг алдахгүй л байсан даа гэж муур хашхирчээ.

1.1 Муур яагаад үнэг авхайд дээдийн дээдээр аашилсан бэ? /1 оноо /

- А. Үнэг тун ухаантай, юм үзэж нүд тайлсан, нэр нүүртэй
- Б. Үнэг ихэрхүү дээрэлхүү зантай тул
- В. Үнэг зуу гаруй авьяастай, уут дүүрэн арга зальтай тул
- Г. Нохойноос хэрхэн зугтах аргыг зааж өгсөн тул
- Д. Энэ бэрх цагт аж төрөхөд тусалсан.

1.2 Эхэд гарсан “ Юм үзэж нүд тайлсан” гэсэн хэлц үгийн утгыг олоорой. /1 оноо/

- А. Олон газраар явж, туршлага судалсан.
- Б. Эрх мэдэл бүхий эзэн
- В. Юмны арга эвийг сайн олдог.
- Г. Заль мэхтэй овжин

1.3. Зөв харгалзуулсан хэсгийг сонгоорой.

- 1. Эхлэл А. Би цорын ганц авьяастай гэж муур хариулав.

2. Гол Б. Хэрвээ та над шиг мод өөд авчирч чаддаг сан бол амиа алдахгүй л байсан даа гэж муур хашхирчээ.
3. Төгсгөл В. Муур үнэг авхайтай ойд учрах тохиолдол таарчээ.

A. 1а, 2б, 3в Б. 1б, 2в, 3а В. 1в, 2а, 3б Г. 1в, 2б, 3а

1.4 Дараах үгнээс “ийг” залгаврыг залгах үгийг олж дугуйлаарай

A. сансар В. бодлого С. шавж D. тосгон

1.5. “Ж, Ч, Ш”-ийн дүрмээр бичигдсэн үгийг олоорой. / 1 оноо/

A. гортиг Б. сонин В. хачин Г. морил

1.6 “Өлбөгөр” гэдэг үгийн утгыг зөв тайлбарласан хэсэг аль вэ? / 1 /

- A. Хүч тэнхээтэй
 B. Тамир тэнхээ муутай
 C. Гунигласан
 D. Сагсуу онгиороо

1.7 Урья гэсэн үгтэй ижил дүрмээр бичигдсэн үгийг олоорой.

A. Урья В. Уяя С. зорьё D. очъё

1.8 Үгсийг тохирох дүрэмтэй нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

- | | | |
|----------|----|---|
| 1.Мордъё | а. | гийгүүлэгчээр төгссөн эм үгэнд “е” залгахдаа “ь” бичиж тусгаарлана. |
| 2.Хоноё | б. | гийгүүлэгчээр төгссөн эр үгэнд “я,ё” залгахдаа “ь” бичиж тусгаарлана. |
| 3.Мэдьё | в. | эгшгээр төгссөн үгэнд “е,я,ё” шууд залгана. |
| 4.Зорьё | г. | ь тэмдгээр төгссөн үгэнд “е,я,ё” шууд залгана. |

A. 1а 2б 3в 4г В. 1б 2в 3в 4а С. 1б 2в 3а 4г D. 1а 2в 3а 4б

1.9 Дараах үгийн эсрэг утгыг нэрлэсэн үгийг олоорой. Шалмаг-

A. Хурдан Б. Удаан В. Онцгой Г. Хэрсүү

1.10 Үлгэрт тохирох зүйр үгийг сонгоорой. \ 1 оноо \

- A. Гэм нь урдаа, гэмшил нь хойноо
 Б. Дэм дэмэндээ, дээс эрчиндээ
 В. Харамласан юм хар нохойны идэш
 Г. Зовох цагт, нөхрийн чанар танигдана.

ХОЁР: БИЧИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

Санамж: Даалгаврыг өгөгдсөн зайд зөв бичих дүрмийн алдаагүй, хичээнгүй бичиж гүйцэтгээрэй.

2.1 Муур үнэгэнд юу гэж хариулсан бэ? \2 оноо\

2.2 Балархай эгшгийн үүргийг зөв холбоорой. \3 оноо\

- | | |
|------------|-----------------------------------|
| 1. шударга | A. зөөлөрснийг тэмдэглэх үүрэгтэй |
| 2. найдвар | Б. эгшигжүүлэх үүрэгтэй |
| 3. анги | В. ялгах үүрэгтэй |

2.3 Дараах хэлц үгийн утгыг зөв тайлбарлаад өгүүлбэр зохиогоорой. /2 оноо/

1. Модоо барих-

2.

.....

Суралцагчийн нэр

ХУГАЦАА – 60 МИН

“Б” ВАРИАНТ

НИЙТ ОНОО –24

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй.

Үнэг ба муур

Нэгэн удаа муур үнэг авхайтай ойд учрах тохиолдол таарчээ. Үнэг тун ухаантай, юм үзэж нүд тайлсан, нэр нүүртэй гэдгийг мэдэх тул муур дээдийн дээдээр аашлан, түүнд хандаж,

- Амрыг эрье. Хонгорхон үнэг авхай, ойрд та амгалан сайн уу ? Энэ бэрх цагт хэр аж төрж сууна даа? хэмээв. Ихэрхүү зальт үнэг муурыг хөлөөс толгой хүртэл шинжин харж хариулъя уу, байя уу гэж баахан тээнэглэсэнээ:

-Оготгно барьдаг өлбөгөр лүд. Алаг эрээн мангуу минь, чи яасан тэнэг юм ! Хэр аж төрж сууна уу? гэж надаас яаж асууж зүрхэлнэ вэ? Чи ер нь юу сурсан амьтан бэ? Ямар авьяастай вэ? гэж байцаажээ.

-Би цорын ганц авьяастай гэж муур даруухан хариулав.

-Тэр чинь ямар авьяастай вэ? гэж үнэг асуужээ.

-Хэрэв нохой хойноос минь хөөвөл модон дээр үсрэн гарч, амиа хамгаалж чадна.

Энүүхэн үү? гэсэнээ би зуу гаруй авьяастай. Түүнээс гадна бас уут дүүрэн заль мэхтэй.

Би чамайг хачин их өрөвдөж байна. Миний араас дагаад яв. Нохойноос хэрхэн нуугдах аргыг би чамд зааж өгье хэмээн үнэг сайрхав.

Яг энэ үед анчин дөрвөн нохой дагуулсаар гарч ирэхэд муур шалмаг гэгч нэгэн модон дээр үсрэн гарч, модны оройд мөчир навчинд халхлагдан суужээ.

-Уутаа онгойлгооч, үнэг авхай, уутаа онгойлго л доо ! гэж муур үнэг уруу хашхирсан боловч ноход хэдийнээ түүнийг зуусан байв.

-Үнэг авхай минь. Хэрвээ та над шиг мод өөд авчирч чаддаг сан бол хар амиа бодож, өөрийнхөө амийг алдахгүй л байсан даа гэж муур хашхирчээ.

1.1 Үнэг яагаад ноходод зуулгасан бэ? /1оноо/

А. Энэ бэрх цагт аж төрөхөд тусалсан.

Б. Үнэг ихэрхүү дээрэлхүү зантай тул

В. Үнэг зуу гаруй авьяастай, уут дүүрэн арга зальтай тул

Г. Нохойноос зугтах арга байгаагүй тул

Д. Нохойноос хэрхэн зугтах аргыг зааж өгсөн тул

1.2 Эхэд гарсан “ Хар амиа бодох” гэсэн хэлц үгийн утгыг олоорой. /1 оноо/

А. Бусдыг бодож туслах.

Б. Зөвхөн өөрийгөө бодох

В. Юмны арга эвийг сайн олдог.

Г. Заль мэхтэй овжин

1.3. Зөв харгалзуулсан хэсгийг сонгоорой.

1.Би цорын ганц авьяастай гэж муур хариулав.

А. Эхлэл

2. Хэрвээ та над шиг мод өөд авчирч чаддаг сан бол

Б. Гол

амиа алдахгүй л байсан даа гэж муур хашхирчээ.

3. Муур үнэг авхайтай ойд учрах тохиолдол таарчээ.

В. Төгсгөл

А. 1а, 2б, 3в

Б. 1б, 2в, 3а

В. 1в, 2а, 3б

Г. 1в, 2б, 3а

1.4 Дараах үгнээс “ийг” залгаврыг залгах үгийг олж дугуйлаарай

А. горхи

В. Самбар

С. шалгуур

Д. тосгон

1.5. “ Ж, Ч, Ш ”-ийн дүрмээр бичигдсэн үгийг олоорой. / 1 оноо/

А. тамир

Б. чимээ

В. ширдэг

Г. хашир

1.6 “Халхлагдах” гэдэг үгийн утгыг зөв тайлбарласан хэсэг аль вэ? / 1 /

- A. Халх үндэстэн
- B. Ил харагдах
- C. Юмны цаагуур орж харагдахгүй болох
- D. Олдохгүй болох

1.7 Таръя гэсэн үгтэй ижил дүрмээр бичигдсэн үгийг олоорой.

- A. Урья
- B. Уяя
- C. зорьё
- D. Бооё

1.8 Үгсийг тохирох дүрэмтэй нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

- 1. Бодъё а. гийгүүлэгчээр төгссөн эм үгэнд “е” залгахдаа “ь” бичиж тусгаарлана.
- 2. Саная б. гийгүүлэгчээр төгссөн эр үгэнд “я,ё” залгахдаа “ь” бичиж тусгаарлана.
- 3. Нүдые в. эгшгээр төгссөн үгэнд “е,я,ё” шууд залгана.
- 4. Барья г. ь тэмдгээр төгссөн үгэнд “е,я,ё” шууд залгана.

- A. 1а 2б 3в 4г
- B. 1б 2в 3в 4а
- C. 1б 2в 3а 4г
- D. 1а 2в 3а 4б

1.9 Дараах үгийн ойролцоо утгыг нэрлэсэн үгийг олоорой. **Эрээн** -

- A. Цулгай
- B. Хар
- C. Цагаан
- G. Алаг

1.10 Үлгэрт тохирох зүйр үгийг сонгоорой. \ 1 оноо \

- A. Айл хүний амь нэг, саахалт айлын санаа нэг
- B. Сайныг дагавал сарны гэрэл, мууг дагавал могойн хор
- B. Яарвал даарна, ядарвал зүдэрнэ
- G. Санаа муут яван хатна, сарьсан багваахай наранд хатна

ХОЁР: БИЧИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

Санамж: Даалгаврыг өгөгдсөн зайд зөв бичих дүрмийн алдаагүй, хичээнгүй бичиж гүйцэтгээрэй.

2.2 Муур юу гэж хашхирсан бэ? \2 оноо\

2.2 Балархай эгшгийн үүргийг зөв холбоорой. \3 оноо\

- 1. бугалга А. зөөлөрснийг тэмдэглэх үүрэгтэй
- 2. хуулбар Б. эгшигжүүлэх үүрэгтэй
- 3. занги В. ялгах үүрэгтэй

2.3 Дараах хэлц үгийн утгыг зөв тайлбарлаад өгүүлбэр зохиогоорой. /2 оноо/

- 1. Магнай тэнийх-
- 2.

2.4 Дараах холбоос үгийг зөв харгалзуулан холбоорой. /2 оноо/

- 1. Бас, боловч
- а. Өгүүлбэр ба цогцолборыг

